| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 2,105,714,000.00 | 2,015,258,074.68 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 2,071,714,100.00 | 1,987,665,012.68 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 1,289,850,000.00 | 1,253,638,035.16 |
| 210101 | Үндсэн цалин | 976,393,500.00 | 875,720,818.70 |
| 210102 | Нэмэгдэл | 220,940,100.00 | 299,221,548.79 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 5,940,000.00 | 4,849,418.67 |
| 210104 | Урамшуулал | 83,476,400.00 | 70,746,249.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 3,100,000.00 | 3,100,000.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 168,288,100.00 | 162,457,366.52 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 118,651,700.00 | 117,800,539.97 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 12,409,100.00 | 11,654,631.31 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 9,927,300.00 | 9,272,719.16 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,481,800.00 | 1,771,274.32 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 24,818,200.00 | 21,958,201.76 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 264,328,300.00 | 249,888,292.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 17,863,300.00 | 13,217,086.00 |
| 210302 | Түлш, халаалт | 243,288,300.00 | 234,914,806.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 3,176,700.00 | 1,756,400.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 88,262,000.00 | 83,264,643.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 4,737,900.00 | 4,863,800.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 43,472,000.00 | 41,656,150.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 9,071,000.00 | 7,595,738.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 12,635,700.00 | 12,485,480.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 5,249,800.00 | 3,638,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 13,095,600.00 | 13,025,475.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 84,941,200.00 | 74,322,947.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 22,151,900.00 | 21,241,526.00 |
| 210502 | Хоол, хүнс | 60,140,700.00 | 50,665,041.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 2,648,600.00 | 2,416,380.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 38,799,500.00 | 38,562,724.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 17,063,000.00 | 17,043,600.00 |
| 210604 | Урсгал засвар | 21,736,500.00 | 21,519,124.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 6,601,800.00 | 4,675,600.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 6,601,800.00 | 4,675,600.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 25,041,200.00 | 21,645,060.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 20,182,400.00 | 18,908,254.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 1,897,200.00 | 335,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 590,000.00 | 517,616.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 755,000.00 | 492,750.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 114,000.00 | - |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,400,000.00 | 1,319,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 102,600.00 | 72,440.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 105,602,000.00 | 99,210,345.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 101,839,800.00 | 95,914,545.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 3,762,200.00 | 3,295,800.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 33,999,900.00 | 27,593,062.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 33,999,900.00 | 27,593,062.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 6,783,300.00 | 4,146,240.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 23,769,500.00 | 21,718,122.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 3,447,100.00 | 1,728,700.00 |
| **23** | **ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ** | 120,000,000.00 | 100,000.00 |
| 230001 | Эргэж төлөгдөх зээл | 120,000,000.00 | 100,000.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 2,341,657,500.00 | 2,289,588,274.00 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 1,190,567,000.00 | 1,190,566,900.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 1,190,567,000.00 | 1,190,566,900.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 814,594,700.00 | 925,926,600.00 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 720,917,900.00 | 832,249,800.00 |
| 132007 | Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих | 93,676,800.00 | 93,676,800.00 |
| **1340** | **НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 29,839,800.00 | 25,952,280.00 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 29,839,800.00 | 25,952,280.00 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 306,656,000.00 | 147,142,494.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 83,626,000.00 | 89,299,944.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 48,744,700.00 | 57,842,550.00 |
| 1200043 | Урьд оны үлдэгдлээс санхүүжих | 174,285,300.00 | - |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | 63,714,915.50 |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | 147,163,209.55 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **127,410,526.00** | **205,659,891.61** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **127,410,526.00** | **205,659,891.61** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 77,410,526.00 | 172,533,418.61 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 5,625,000.00 | 26,565,480.00 |
| 210101 | Үндсэн цалин | 5,625,000.00 | 50,713.56 |
| 210102 | Нэмэгдэл | | 26,514,766.44 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | | 3,958,765.61 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | | 2,835,690.47 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | | 283,998.48 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | | 227,198.75 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | | 55,625.30 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | | 556,252.61 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 3,902,900.00 | 13,881,624.00 |
| 210401 | Бичиг хэрэг | | 1,031,544.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 3,902,900.00 | 7,063,930.00 |
| 210404 | Ном, хэвлэл | | 1,757,200.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | | 4,028,950.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 2,000,000.00 | 62,697,754.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 2,000,000.00 | 58,697,754.00 |
| 210502 | Хоол, хүнс | | 4,000,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 90,000.00 | 226,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 90,000.00 | 226,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 61,852,626.00 | 44,143,750.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 61,852,626.00 | 44,143,750.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 3,940,000.00 | 21,060,045.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 3,940,000.00 | 20,660,045.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | | 400,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 10,000,000.00 | 30,000,000.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 10,000,000.00 | 30,000,000.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | | 30,000,000.00 |
| **2133** | **Олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 10,000,000.00 | 3,126,473.00 |
| 213303 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг | | 701,476.00 |
| 213403 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг | | 2,424,997.00 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | 40,000,000.00 | - |
| 223001 | Бусад хөрөнгө | 40,000,000.00 | |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **127,410,526.00** | **205,659,892.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **127,410,526.00** | **205,659,892.00** |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 82,000,000.00 | 102,812,230.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 45,410,526.00 | 98,402,962.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | | 4,444,700.00 |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | 0.39 |

## 3.Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Бүрд сумын Төрийн сангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитыг 2022.03.09-өөс 2022.03.23–ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2022.03.23-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Өвөрхангай аймаг дахь төрийн аудитын газрын аудитор Р.Энхзул хариуцаж хэрэгжүүлэв.

Тус байгууллага нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Өвөрхангай аймаг дахь төрийн аудитын газарт 2022.03.09-ний өдрийн 1/50 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

Сумын төрийн сангийн нэгтгэсэн тайланд 6 төсөвт байгууллага, 4 сан, 1 ерөнхий орлогын данс, нийт 11 тайлан нэгтгэгджээ.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Төсвийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1."Төсвийн ерөнхийлөн захирагч нь өөрийн удирдлага дор төсвийн шууд захирагчийг харьяалах эрх бүхий төсвийн төвлөрүүлэн захирагчтай байж болно." гэж заасан.

Мөн хуулийн 36.1."Төрийн сангийн тогтолцоо нь төв төрийн сан, аймаг, нийслэлийн төрийн сан, сум, дүүргийн төрийн сан, төрийн захиргааны төв байгууллагын төрийн сангийн нэгж, төсвийн нягтлан бодогч /цаашид "төрийн сан" гэх/-оос бүрдэнэ.

36.2.Төв төрийн сан нь санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад, аймаг, нийслэл, сум, дүүргийн төрийн сан нь тухайн шатны Засаг даргын Тамгын газрын дэргэд байна.

36.3.Сум, дүүрэгт үйл ажиллагаа явуулж байгаа төсвийн байгууллагын үйл ажиллагааны чиглэл болон төсвийн хэмжээг нь харгалзан төрөлжүүлж, тэдгээрт хамаарах төсвийн байгууллагуудад нягтлан бодох бүртгэлийн үйлчилгээ үзүүлэх нэгдсэн алба байгуулж болно" гэсэн заалтуудаар зохицуулагдаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Бүрд сумын Төрийн сангийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн

байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Бүрд сумын Төрийн сангийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны нийт зардлын 3616.2 сая төгрөгөөс 1 хувиар буюу 36.2 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 28.9 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

#### 3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл өмнөх оноос 415.3 сая төгрөгөөр өссөн байна.

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Зөрүү |
|---|---|---|---|---|
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 171.6 | 586.9 | 415.3 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 171.6 | 586.9 | 415.3 |

Дараах байгууллагуудын данс мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй гарсан байна.

- Эрүүл мэндийн төв – 0.1 сая төгрөг
- Сум хөгжүүлэх сан – 126.0 сая төгрөг
- Эрсдэлээс хамгаалах сан – 13.2 сая төгрөг
- Орон нутгийн хөгжлийн сан – 7.9 сая төгрөг
- Орон нутгийн ерөнхий орлого – 439.7 сая төгрөг

### 3.5.2 Авлага

| Дансны код | Балансын үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он | Зөрүү |
|---|---|---|---|---|
| 33 | АВЛАГА | 276.0 | 258.4 | (17.6) |
| 33100 | Төлбөртэй үйлчилгээний авлага | - | 75.9 | 75.9 |
| 33300 | Татаас, санхүүжилтийн авлага | 3.0 | - | (3.0) |
| 33400 | Зээлийн хүүгийн авлага | 5.6 | 4.6 | (1.0) |
| 33402 | Татвар, НДШ – ийн авлага /ТӨҮГ/ | 3.2 | 0.9 | (2.3) |
| 33510 | Байгууллагаас авах авлага | 1.1 | 1.1 | - |
| 33520 | Хувь хүмүүсээс авах авлага | 263.1 | 175.9 | (87.2) |

Тайлант онд нийт авлага 17.6 сая төгрөгөөр буурсан байна.

### 3.5.3 Бараа материал

Бараа материалын үлдэгдэл өмнөх оноос 50.4 сая төгрөгөөр өссөн байна.

| Дансны код | Балансын үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он | Зөрүү |
|---|---|---|---|---|
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 191.4 | 241.8 | 50.4 |
| **351** | **Түүхий эд материал** | 12.6 | 60.6 | 48.0 |
| **354** | **Хангамжийн материал** | 178.8 | 181.2 | 2.4 |

Тайлант онд бараа материал ЗДТГ 3.8 сая төгрөг, ЭМТөв 51.5 сая төгрөг, Соёлын төв 0.7 сая төгрөг, ИТХ 0.4 сая төгрөгөөр тус тус өсөж, , ЕБС 5.3 сая төгрөг, Цэцэрлэг 0.7 сая төгрөгөөр тус тус буурсан байна.

### 3.5.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн үлдэгдэл өмнөх оноос 217.9 сая төгрөгөөр өссөн байна.

| № | Үзүүлэлт | Хөрөнгийн дүн |
|---|---|---|
| **1** | **Үндсэн хөрөнгийн оны эхний үлдэгдэл** | **9,327.6** |
| **2** | **Нэмэгдсэн** | **485.1** |
| 201 | Худалдан авсан | 23.3 |
| 202 | Хандиваар | 2.1 |
| 203 | Шилжүүлэн авсан | 319.3 |
| 205 | Бусад | 140.4 |
| **3** | **Хасагдсан** | **267.2** |
| 302 | Акталсан | 231.6 |
| 303 | Шилжүүлсэн | 35.6 |
| **4** | **Үндсэн хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **9,545.5** |

Бүрд сумын Төрийн сангийн үндсэн хөрөнгийн тодруулга тайлангийн нэгтгэлээр 485.1 сая төгрөгийн хөрөнгө шинээр бүртгэлд тусгаснаас 23.3 сая төгрөгийн хөрөнгийг төсвийн хөрөнгөөр, 319.3 сая төгрөг шилжүүлэн, 142.5 сая төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүйгээр хүлээн авч бүртгэлд тусгажээ. Харин 231.6 сая төгрөгийн хөрөнгийг акталж, 35.6 сая төгрөгийн хөрөнгийг шилжүүлэн тус тус данснаас хассан байна.

### 3.5.5 Өр төлбөр

| Дансны код | Балансын үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он | Зөрүү |
|---|---|---|---|---|
| **413** | **Өглөг** | 7.6 | 77.4 | 69.8 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 4.0 | 60.7 | 56.7 |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | 3.1 | 5.5 | 2.4 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 0.5 | 11.2 | 10.7 |

Тайлант онд өр төлбөр 69.8 сая төгрөгөөр өссөн. ЭМТ 72.7 сая төгрөг, СХС 1.1 сая төгрөгөөр нэмэгдэж, Цэцэрлэг 1.7 сая төгрөг, Соёлын төв 2.3 сая төгрөгөөр буурсан байна. ЭМТ-ийн өр нь ажилчдын цалинд 60.7 сая төгрөг, бараа үйлчилгээний зардалд 2.4 сая төгрөг, байгууллагад 9.6 сая төгрөгөөр эм болон бараа материалын өр байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

### 3.6.1 Орон нутгийн төсвийн орлого бүрдүүлэлт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Сумын ИТХ-ын 2020 оны тогтоолоор орон нутгийн төсөвт төвлөрүүлэх татварын болон татварын бус орлогыг 81.8 сая төгрөгөөр баталжээ. Гүйцэтгэлээр 456.3 сая төгрөгийн орлого төвлөрч, орлогын төлөвлөгөө 374.5 сая төгрөг буюу 557.8 хувиар давуулан биелүүлсэн байна.

| № | Орлогын төрөл | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| 1 | Үйл ажиллагааны орлого | 28.3 | 24.1 | (4.2) | 85.2% |
| 2 | Улсын тэмдэгтийн хураамж | 2.0 | 1.7 | (0.3) | 85.0% |
| 3 | Хог хаягдлын хураамж | 4.5 | 7.5 | 3.0 | 166.7% |
| 4 | Ан амьтны нөөц ашигласны төлбөр | - | 273.0 | 273.0 | |
| 5 | Газрын төлбөр | 1.6 | 2.1 | 0.5 | 131.3% |
| 6 | Хөрөнгө борлуулсаны орлого | - | 1.1 | 1.1 | |
| 7 | Бууны албан татвар | 1.9 | 2.0 | 0.1 | 105.3% |
| 8 | Малын албан татвар | - | 62.7 | 62.7 | |
| 9 | Хүү,торгуулийн орлого | - | 32.7 | 32.7 | |
| 10 | Хадгаламжийн орлого | 43.5 | 49.4 | 5.9 | 113.6% |
| | Нийт орлогын дүн | 81.8 | 456.3 | 374.5 | 557.8% |

### 3.6.2 Орон нутгийн төлөвлөлт, гүйцэтгэл

2021 онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн үйл ажиллагааг санхүүжүүлэхээр 2341.6 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 1190.6 сая төгрөгийг улсын төсвөөс, 814.6 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 29.8 сая төгрөгийг нийгмийн даатгалын сан, 306.6 сая төгрөгийг үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1190.6 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 925.9 сая төгрөг, нийгмийн даатгалын сангаас 25.9 сая төгрөг, төсөвт байгууллагын үйл ажиллагаа болон санхүүгийн дэмжлэгээр 147.2 сая төгрөг, нийт 2289.6 сая төгрөгийн санхүүжилт, болон орлогын эх үүсвэр бүрдүүлжээ.

Үүнээс бараа үйлчилгээний зардалд 1987.7 сая төгрөг, эргэн төлөгдөх зээлд 0.1 сая төгрөг, урсгал шилжүүлэгт 27.6 сая төгрөгийг зарцуулжээ.

**Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт төсвийн дансаар сумын хэмжээнд 205.6 сая төгрөгийн санхүүжилт авч бараа үйлчилгээний зардалд 172.5 сая төгрөг, урсгал шилжүүлэгт 30.0 сая төгрөгийг зарцуулж, 3.1 сая төгрөгийг төвлөрүүлжээ.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Асуудлын онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэгт онцлон дурдах зүйл байхгүй байна.

### 3.8 Аудитын гол асуудал

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 2 чиглэлээр аудитын 2 горим сорил гүйцэтгэсэн.

Материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ, үйл явдлыг аудитын гол асуудлыг тодорхойлоход харгалзаж үзсэн.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Бүрд сумын Төрийн сан нь 2021 онд 154 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршуулахаас 111 мэдээллийг ил тод хугацаанд нь, мэдээлэл оруулаагүй 16 мэдээлэл, хугацаа болоогүй 2 мэдээлэл, 25 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны аудитаар алдаа, зөрчил илрээгүй.

### 3.11 Аудитын үр өгөөжийн тооцоолол

Төлөвлөлтийн шатанд 2.0 сая төгрөгийн үр өгөөжийг төлөвлөсөн. Аудитаар тооцож бүртгэсэн үр өгөөж байхгүй.

## 4. Аудитын илрүүлэлт

Бүрд сумын Төрийн сангийн 2021 оны нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа зөрчил илрээгүй.

### 4.1 Харьяа байгууллагуудад илэрсэн зөрчлийн талаар

Аудитад хамрагдсан 8 байгууллагын 3 байгууллагад дүгнэлт гаргаж, /ЭМТ, ЕБС, Соёлын төв, / 5 байгууллагыг түүвэрт хамруулсан / ЗДТГ, ИТХ, Цэцэрлэг, ОНХСан, СХСан/

Харьяа байгууллагуудын зөрчлийн нэгтгэлээр 1679.8 сая төгрөгийн алдаа зөрчил илэрч 182.1 сая төгрөгийн алдааг залруулж, 1454.5 сая төгрөгийн 9 албан шаардлага, 43.2 сая төгрөгийн 5 зөвлөмжийг хүргүүлсэн.

- *Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилттэй холбоотой нийт **0.4** сая төгрөгийн зөрчил илэрсэн. Үүнд:*

*ИТХ- Хөдөлмөр хамгаалалын 0.4 сая төгрөгийн хувцас авсан.*

- *Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой **225.9** сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн.*

*Соёлын төв- Газар эзэмших эрх, номын фонд дансны хөрөнгийн ашиглах хугацааг 0 жилээр тооцож санхүүгийн программд тусгасан.*

*Бусад үндсэн хөрөнгийн дансанд газар, номыг хамт бүртгэсэн байна. Алдааны дүн 22.8 сая төгрөг*

*Номын фондын номыг бөөн дүнгээр бүртгэсэн тул тоо ширхэг, нэгж үнэ нь тодорхойгүй байгаагаас тооллогод хамрагдсан эсэх, хөрөнгө бодитоор оршин буй эсэх нь тодорхойгүй байна. Алдааны дүн 20.4 сая төгрөг*

*Цэцэрлэг- Ашиглаж буй санхүүгийн программ нь нягтлан бодох бүртгэлийн шаардлага хангахгүй байгаагаас журнал, тайлангууд нь зохих түвшинд бэлтгэгдэхгүй байна.*

*Төсвийн санхүүжилтээс төрийн санд буцаан төвлөрүүлсэн мөнгөн хөрөнгийг төсвийн гүйцэтгэлд оруулж тайлагнасан. Алдааны дүн 4.0 сая төгрөг*

*ЕБС- Тухайн байгууллагад ашиглагдаж байгаа нягтлан бодох бүртгэлийн програм хангамж Сангийн яамнаас тогтоосон шаардлагыг хангаагүй байх*

*ИТХ-н тогтоолоор Хуучин Дотуур байрны барилга, газрын хамт актлагсан байсныг данснаас хасаагүй. Алдааны дүн 166.2 сая төгрөг*

*Мөнгөн гүйлгээний тайлангийн биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал үндсэн хөрөнгийн тодруулга тайлангийн худалдан авсан хөрөнгийн дүнгээс зөрүүтэй тайлагнасан. Алдааны дүн 3.4 сая төгрөг*

*СХС- Тайлант онд харилцах дансаар 89.3 сая төгрөгийн орлого орсоноос 82.0 сая төгрөгийн орлого орсоноор тайлагнаж 7.3 сая төгрөгөөр орлогыг мөнгөн гүйгээний тайланд дутуу тайлагнасан.*

*Эрсдлээс хамгаалах сангийн 1.1 сая төгрөгийн гүйлгээг шилжүүлээгүй мөнгөн хөрөнгөнд үлдсэн боловч өглөгөөр бүртгээгүй*

*ЭМТ- Үндэслэх баримт шийдвэргүйгээр авлагыг найдваргүй авлагын зардалд хаасан. Зөрчлийн дүн 0.7 сая төгрөг*

- *Дотоод хяналт хариуцлагатай холбоотой **1403.2** сая төгрөгийн зөрчил илэрсэн.*

*Соёлын төв- Бараа материалын тайлан болон орлого, зарлага, шаардах хуудсыг батлагдсан маягтын дагуу хөтлөж тайланг гаргаагүй байна.*

*Шатахуун зарцуулалтын анхан шатны баримт бүрдүүлээгүй, замын хуудас үйлдэж тооцоо бодоогүйгээс 2.9 сая төгрөгийн зардлыг зориулалтын дагуу зарцуулсан эсэх нь тодорхойгүй байна.*

*Тус байгууллагын жилийн эцсийн тооллогын комиссын тушаал гарсан боловч үндсэн хөрөнгө болон бараа материалын нийт 1,377.9 сая төгрөгийн хөрөнгийн тооллого хийсэн эсэх нь баримтаар нотлогдохгүй байна. Мөн хагас жилийн тооллого хийсэн баримт материал байхгүй байна.*

*Цэцэрлэг- Бараа материалын тайланд сүүлийн 3 жил дараалан тайлагнасан хүнсний материалын 22.4 сая төгрөгийн үлдэгдэл бодитоор оршин буй эсэх нь тодорхойгүй, уг үлдэгдлийг шийдвэрлэх талаар тооллогын комиссоос ямар нэг санал гаргаагүй байна.*

- *Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой **1.6** сая төгрөгийн дараах зөрчил илэрсэн.*

*ЗДТГ- Анхан шатны баримтын бүрдэл дутуу баримтаар 1.0 сая төгрөгийн ажил гүйлгээ хийсэн.*

*ИТХ-Анхан шатны баримтын бүрдэл дутуу баримтаар 0.6 сая төгрөгийн ажил гүйлгээ хийсэн.*

- *Нийцлийн аудитаар **48.7** сая төгрөгийн зөрчил илэрсэн.*

*ЭМТ- Шилэн дансны сайтад 5.3 сая төгрөгийн худалдан авалтыг байршуулаагүй байна.*

*ОНХС-Хөрөнгийг зарцуулахтай холбоотой 3 төрлийн 43.4 сая төгрөгийн шийдвэрийг шилэн дансны сайтад мэдээлээгүй байна.*

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

(сая төгрөгөөр)

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| | Бүрд сумын Төрийн сан | 0 | 0 | 0 | 00 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР О.БАТЖАРГАЛ

АУДИТЫН МЕНЕЖЕР Д.ГАНСҮХ

БЭЛТГЭСЭН: АУДИТОР Р.ЭНХЗУЛ

2022 ОНЫ 03 ДУГААР САРЫН 23-НЫ ӨДӨР